

## ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖААР ЗОРЧИЖ БУЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС ЗАМ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР АВАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Журмын зорилго нь: Хэнтий аймгийн орон нутгийн чанартай авто зам болон Чингис хот доторх зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Төлбөр авах үйл ажиллагаа

2.1. Хэнтий аймгийн орон нутгийн чанартай авто зам болон Чингис хот доторх зам, замын байгууламжаар зорчиж буй тээврийн хэрэгслээс зам ашигласны төлбөр авах, төлбөрийг орон нутгийн замын санд төвлөрүүлэх ажлыг аймгийн Авто тээврийн төв зохион байгуулж хэрэгжүүлнэ.

2.2 Орон нутгийн чанартай авто зам болон Чингис хот доторх зам, замын байгууламжаар зорчиж буй 1 тээврийн хэрэгслээс дараах ангиллаар зам ашигласны төлбөр авна. Үүнд:

2.2.1. Хэнтий аймгийн улсын бүртгэл/дугаар/-тэй тээврийн хэрэгслээс орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг жилд нэг удаа авто тээврийн улсын үзлэгийн үед тогтоосон хэмжээгээр авч гэрчилгээ олгоно.

2.2.2. Хэнтий аймгаас бусад аймаг, хотын улсын бүртгэл /дугаар/-тэй тээврийн хэрэгслээс орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг төлбөр авах цэгүүдээр нэвтрэх тухай бүрд тогтоосон хэмжээгээр авч тасалбар олгоно.

2.3. Тээврийн хэрэгслийн жолооч нарт олгох гэрчилгээ болон тасалбарын загварыг аймгийн Авто тээврийн төвийн даргын шийдвэрээр батлан хэвлүүлж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр баталгаажуулж, үнэт цаасны тооцоог хянуулна.

**ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ  
АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

1. Хэнтий аймгийн бүртгэл /улсын дугаар/-тэй тээврийн хэрэгслээс жилд 1 удаа авах төлбөр

№	Мотоцекль, мопед	Суудлын авто машин	Ачааны машины даац			Автобусны багтаамж /зорчигчийн тоо/			
			3.5 тн хүртэл	3.5 тн-оос 12.0 тн хүртэл	12.1 тн-оос дээш	12 хүртэл	12-24	25-аас дээш	механизм
Төлбөрийн хэмжээ	1000	10000	10000	12000	15000	10000	12000	15000	10000

2. Бусад аймаг хотын бүртгэл /улсын дугаар/-тэй тээврийн хэрэгслээс төлбөр авах цэгт тухай бүр авах төлбөр

№	Мотоцекль, мопед	Суудлын авто машин	Ачааны машины даац			Автобусны багтаамж /зорчигчийн тоо/			
			3.5 тн хүртэл	3.5 тн-оос 12.0 тн хүртэл	12.1 тн-оос дээш	12 хүртэл	12-24	25-аас дээш	механизм
Төлбөрийн хэмжээ	100	500	1000	3000	5000	500	1200	1500	1500

ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖААР ЗОРЧИЖ БУЙ  
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭС ТӨЛБӨР ХУРААХ ЦЭГҮҮДИЙН БАЙРШИЛ

№	Чиглэл	Цэгийн байршил	Авто замын ангилал
1	Баянхутаг, Галшар, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сумаас Чингис хотын чиглэлд	Хэрлэн сум 1 дүгээр баг хийд	Орон нутгийн чанартай зам
2	Батширээт, Биндэр, Баян-Адрага, Өмнөдэлгэр, Хурх тосгоноос Чингис хотын чиглэлд	Хэрлэн сум 3 дугаар баг Цогт-Өндөр	Орон нутгийн чанартай зам